



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 07 сарын 07-ны  
өдрийн 6302 дугаарт бүртгэв.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

1518000561



## **ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч (цаашид “Арилжаа эрхлэгч” гэх)-ийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшнийг тодорхойлж, түүнд үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Хорооноос баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-аар арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалттай холбоотой нийтлэг харилцааг зохицуулж, энэ журмаар нарийвчилсан харилцааг зохицуулна.

1.3.Хороо хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ “Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын бодлогын баримт бичиг”-т заасан зарчмыг баримтална.

1.4.Холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд энэ журмыг баримталж болно.

### **ХОЁР.ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР**

2.1.Хорооноос хийх хяналт шалгалт нь дараах төрөлтэй байна:

2.1.1.зайны хяналт шалгалт;

2.1.2.газар дээрх хяналт шалгалт.

2.2.Хяналт шалгалтыг хянан шалгагч, улсын байцаагч хэрэгжүүлнэ. Газар дээрх хяналт шалгалтыг зөвхөн улсын байцаагчийн эрхтэй хянан шал

гагч хэрэгжүүлж, ажлын хэсгийг удирдана. Шаардлагатай гэж үзвэл бусад албан хаагчийг ажлын хэсгийн гишүүнээр ажиллуулж болно.

2.3.Хянан шалгагч, улсын байцаагч нь хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

### **ГУРАВ.ЗАЙНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ**

3.1.Зайны хяналт шалгалтаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн салбарын болон арилжаа эрхлэгчийн болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

3.2.Зайны хяналт шалгалт нь дараах үе шаттай байна:

3.2.1.арилжаа эрхлэгчээс ирүүлбэл зохих тайлан, мэдээг хянаж, үндсэн үйл ажиллагааны болон цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, санхүү, төлбөрийн чадварт үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.2.2.тайлан, мэдээг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээ нь шаардлага хангаагүй бол тухайн арилжаа эрхлэгчээс шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардах;

3.2.3.шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар, мэдээлэл, холбогдох баримт бичгийг шаардах;

3.2.4.шаардлагатай гэж үзвэл арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх саналыг Хорооны холбогдох удирдлагад танилцуулах.

3.3.Арилжаа эрхлэгчээс ирүүлсэн тайлан мэдээг хянаж, эрсдэлтэй гэж дүгнэсэн тохиолдолд хугацаатай үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлнэ.

### **ДӨРӨВ.ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

4.1.Газар дээрх хяналт шалгалтаар арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтаар тогтоох, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авна.

4.2.Газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөө, шалгалтын удирдамж (цаашид “удирдамж” гэх)-ийг Хорооны дарга батална.

4.3.Газар дээрх хяналт шалгалтыг хамрах цар хүрээгээр нь иж бүрэн, хэсэгчилсэн гэж ангилна.

4.4.Иж бүрэн хяналт шалгалтаар баталсан удирдамжийн хүрээнд холбогдох баримт бичигт тулгуурлан арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж, үнэлэлт, дүгнэлт өгнө.

4.5.Хэсэгчилсэн хяналт шалгалтаар харилцагчдаас болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзсэн хүрээнд арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

4.6.Удирдамжийг хяналт шалгалтад хамрагдах арилжаа эрхлэгч, хуульд заасны дагуу төлөөлж буй этгээдэд танилцуулснаар хяналт шалгалтыг эхлүүлнэ.

4.7.Газар дээрх хяналт шалгалтад хамрагдах арилжаа эрхлэгчээс шалгалтын удирдамжид заасан баримт бичгийг шаардана.

4.8.Газар дээрх хяналт шалгалтын тайлан (цаашид “тайлан” гэх)-г шалгалтад хамрагдсан арилжаа эрхлэгчид удирдамжид заасан хугацаанд танилцуулна.

4.9.Газар дээрх хяналт шалгалт хийхэд арилжаа эрхлэгч, эрх бүхий албан тушаалтныг байлцуулах бөгөөд тухайн этгээд ирээгүй нь уг шалгалтыг хойшлуулах үндэслэл болохгүй.

4.10.Ажлын хэсэг тайланг арилжаа эрхлэгч, хуульд заасны дагуу төлөөлж буй этгээдэд танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулна.

4.11.Тайлантай холбогдуулан хариу шаардсан бол арилжаа эрхлэгч тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

4.12.Тайланг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлантай танилцсанаас хойш 10 хоногийн дотор Хорооны Улсын Ерөнхий байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

4.13.Газар дээрх хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгалтын ажлын хэсэг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

4.14.Газар дээрх хяналт шалгалтын дүнд илэрсэн зөрчил, дутагдалд шалгалтын тайлангаар болон Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг нээх, эсхүл гэмт хэргийн шинжтэй тохиолдолд харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.

### ТАВ.ТАЙЛАН, МЭДЭЭ

5.1.Арилжаа эрхлэгч нь дараах тайлан, мэдээг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар болон албан бичгээр ирүүлнэ:

5.1.1.санхүүгийн байдлын тайлан (Хавсралт 1);

5.1.2.орлогын дэлгэрэнгүй тайлан (Хавсралт 2);

5.1.3.мөнгөн гүйлгээний тайлан (Хавсралт 3);

5.1.4.өмчийн өөрчлөлтийн тайлан (Хавсралт 4);

5.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга (Хавсралт 5).

5.1.6.үнэт металл, үнэт чулууны арилжааны нэгдсэн мэдээлэл (Хавсралт 6);

5.1.7.үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжааны нэгдсэн мэдээлэл (Хавсралт 7);

5.1.8.алтны арилжааны мэдээ (Хавсралт 8);

5.1.9.мөнгөний арилжааны мэдээ (Хавсралт 9);

5.1.10.бусад металлын арилжааны мэдээ (Хавсралт 10);

5.1.11.үнэт чулууны арилжааны мэдээ (Хавсралт 11);

5.1.12.үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжааны мэдээ (Хавсралт 12);

5.1.13.эртний эдлэлийн арилжааны мэдээ (Хавсралт 13).

5.2.Арилжаа эрхлэгч нь арилжаа хийх тухай бүрд хэрэглэгчийн систем, эсхүл цахим төлбөрийн баримтын системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг арилжаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээнэ.

5.3.Арилжаа эрхлэгч нь хэрэглэгчийн системд бүртгэгдсэн арилжааны гүйлгээний мэдээллийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.3-т заасан хугацаанд нэгдсэн системд илгээнэ.

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын нэгдүгээр хавсралт



### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Арилжаа эрхлэгчийн нэр)

0000/СС/ӨӨ  
(мянган төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		..-р сарын ..	...-р сарын ...
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө		
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			

<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: -төрийн		
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг		
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>		
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		

Захирал \_\_\_\_\_ (.....)

Ерөнхий нягтлан бодогч \_\_\_\_\_ (.....)

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын хоёрдугаар хавсралт



**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

(Арилжаа эрхлэгчийн нэр)

0000/СС/ӨӨ  
(мянган төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	
2	Борлуулалтын өртөг	
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	
4	Түрээсийн орлого	
5	Хүүгийн орлого	
6	Ногдол ашгийн орлого	
7	Эрхийн шимтгэлийн орлого	
8	Бусад орлого	
9	Борлуулалт, маркетингийн зардал	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	
11	Санхүүгийн зардал	
12	Бусад зардал	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	
17	Бусад ашиг ( алдагдал)	
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	
19	Орлогын татварын зардал	
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	
	Бусад олз (гарз)	
24	<b>Орлогын нийт дүн</b>	
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	

Захирал \_\_\_\_\_ (.....)

Ерөнхий нягтлан бодогч \_\_\_\_\_ (.....)

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн  
эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд  
зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх  
журам”-ын гуравдугаар хавсралт



**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

0000/СС/ӨӨ

(Арилжаа эрхлэгчийн нэр)

(мянган төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант үеийн дүн
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	
	Буцаан авсан албан татвар	
	Татаас, санхүүжилтийн орлого	
	Бусад мөнгөн орлого	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	
	Ажиллагсдад төлсөн	
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	
	Бараа материал худалдан авахад төлсөн	
	Ашиглалтын зардалд төлсөн	
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	
	Хүүгийн төлбөрт төлсөн	
	Татварын байгууллагад төлсөн	
	Даатгалын төлбөрт төлсөн	
	Бусад мөнгөн зарлага	
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	
	Хүлээн авсан хүүгийн орлого	
	Хүлээн авсан ногдол ашиг	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
	Төрөл бүрийн хандив	

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	
	Төлсөн ногдол ашиг	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	
4	Валютын ханшийн зөрүү	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Захирал \_\_\_\_\_ (.....)

Ерөнхий нягтлан бодогч \_\_\_\_\_ (.....)

“Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдийн засгийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт-шалгалт хийх журам”-ын дөрөвдүгээр хавсралт

0000/СС/ӨӨ  
(мянган төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20... оны 01-р сарын 01-ний үлдэгдэл								
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)								
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	20... оны ... -р сарын ... -ний үлдэгдэл								

Захирал \_\_\_\_\_ (.....)

Ерөнхий нягтлан бодогч \_\_\_\_\_ (.....)

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн  
эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд  
зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх  
журам”-ын тавдугаар хавсралт



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

20... оны .... сарын .....өдөр

\_\_\_\_\_ (Арилжаа эрхлэгчийн нэр)

Үндсэн үйл ажиллагааны чиглэл (төрөл):

- (a) \_\_\_\_\_
- (б) \_\_\_\_\_
- (в) \_\_\_\_\_

Туслах үйл ажиллагааны чиглэл (төрөл):

- (a) \_\_\_\_\_
- (б) \_\_\_\_\_
- (в) \_\_\_\_\_

Салбар, төлөөлөгчийн газрын нэр, байршил:

- (a) \_\_\_\_\_
- (б) \_\_\_\_\_
- (в) \_\_\_\_\_

1. ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

3.МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

№	Мөнгөн хөрөнгийн зүйлс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Касс дахь мөнгө		
2	Банкин дахь мөнгө		
3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө		
4	Нийт дүн		

Тэмдэглэл. (Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой тайлбар, тэмдэглэлийг хийнэ).


4. ДАНСНЫ БОЛОН БУСАД АВЛАГА

4.1. Дансны авлага

№	Үзүүлэлт	Дансны авлага	Найдваргүй авлагын хасагдуулга	Дансны авлага (цэвэр дүнгээр)
1	Эхний үлдэгдэл			
2	Нэмэгдсэн			
3	Хасагдсан (-):			
	-Төлөгдсөн			
	- Найдваргүй болсон			
4	Эцсийн үлдэгдэл			

1.Татвар, нийгмийн даатгалын шимтгэл (НДШ)-ийн авлага

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ААНОАТ-ын авлага		
2	НӨАТ-ын авлага		
3	НДШ – ийн авлага		
4	.....		
5	Нийт дүн		

1.3. Бусад богино хугацаат авлага (төрлөөр нь ангилна)

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Холбоотой талаас авах авлага (эргэлтийн хөрөнгөнд хамаарах дүн)		
2	Ажиллагсдаас авах авлага		
3	Ногдол ашгийн авлага		
4	Хүүгийн авлага		
5	Богино хугацаат авлагын бичиг		
6	Бусад талуудаас авах авлага		
7	.....		
8	Нийт дүн		

Тэмдэглэл. (Дансны авлагыг төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн, төлөгдөх найдваргүй гэж ангилна. Найдваргүй авлагын хасагдуулга байгуулсан арга, гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагын талаар болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ).

--	--

5.БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	...		
2	...		
3	Нийт дүн		

6.БАРАА МАТЕРИАЛ

№	Үзүүлэлт	Бараа материалын төрөл						Нийт дүн
		Түүхий эд материал	Дуусаагүй үйлдвэрлэл	Бэлэн бүтээгдэхүүн	Бараа	Хангамжийн материал	...	
1	Эхний үлдэгдэл (өртгөөр)							
2	Нэмэгдсэн дүн							
3	Хасагдсан дүн (-)							
4	Эцсийн үлдэгдэл (өртгөөр)							
5	Үнийн бууралтын гарз (-)							
6	Үнийн бууралтын буцаалт							
7	Дансны цэвэр дүн*:							
7.1	Эхний үлдэгдэл							
7.2	Эцсийн үлдэгдэл							

\*Дансны цэвэр дүнгийн эхний, эцсийн үлдэгдлийн нийт дүн нь санхүүгийн байдлын тайлан дахь бараа материалын дансны эхний, эцсийн үлдэгдлийн дүнтэй тэнцүү байна.

Тэмдэглэл. (Бараа материалын өртгийг тодорхойлоход ашигласан арга, бараа материалын бүртгэлийн систем, өртөг болон цэвэр боломжит үнийн аль багыг сонгох аргын талаар тайлбар, тэмдэглэл хийнэ).


7. БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БҮЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ (ЭСВЭЛ БОРЛУУЛАХ БҮЛЭГ ХӨРӨНГӨ) БОЛОН ӨР ТӨЛБӨР

Тэмдэглэл. (Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) болон өр төлбөрийн тодорхойлолт, хэмжилтийн суурь, борлуулалт хийгдсэн аль эсвэл хийгдэхэд хүргэсэн нөхцөл байдал, борлуулах арга, хугацаа, хүлээн зөвшөөрсөн олз ба гарз болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ).


8.УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Урьдчилж төлсөн зардал		
2	Урьдчилж төлсөн түрээс, даатгал		
3	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр		
4	....		
5	Нийт дүн		



Тэмдэглэл. (Үндсэн хөрөнгийн анги бүрийн хувьд ашигласан хэмжилтийн суурь; элэгдэл тооцох арга; ашиглалтын хугацаа; дахин үнэлсэн бол дахин үнэлгээ хүчинтэй болсон хугацаа, хараат бус үнэлгээчин үнэлсэн эсэх талаар; үндсэн хөрөнгийн дахин ангилал, түүний шалтгаан; бусад тайлбар тэмдэглэлийг хийнэ).

--	--

10.БИЕТ БУС ХӨРӨНГӨ

№	Үзүүлэлт	Зохиогчийн эрх	Компьютер программ хангамж	Патент	Барааны тэмдэг	Тусгай зөвшөөрөл	Газар эзэмших эрх	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
1	БИЕТ БУС ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/								
1.1	Эхний үлдэгдэл								
1.2	Нэмэгдсэн дүн								
	Өөрөө үйлдвэрлэсэн								
	Худалдаж авсан								
	Үнэ төлбөргүй авсан								
	Дахин үнэлгээний нэмэгдэл								
1.3	Хасагдсан дүн (-)								
	Худалдсан								
	Үнэгүй шилжүүлсэн								
	Акталсан								
	...								
1.4	Эцсийн үлдэгдэл								
2	ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ								
2.1	Эхний үлдэгдэл								
2.2	Нэмэгдсэн дүн								
	Байгуулсан хорогдол								
	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн								
	Үнэ цэнийн бууралтын буцаалт								
2.3	Хасагдсан:								
	Данснаас хассан хөрөнгийн хорогдол								
	Дахин үнэлгээгээр хасагдсан								
	Үнэ цэнийн бууралт								
2.4	Эцсийн үлдэгдэл								
3	ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН								
3.1	Эхний үлдэгдэл (1.1 - 2.1)								
3.2	Эцсийн үлдэгдэл (1.4 - 2.4)								

Тэмдэглэл. (Биет бус хөрөнгийн анги бүрийн хувьд ашигласан хэмжилтийн суурь, хорогдол тооцох арга, ашиглалтын хугацаа, дахин үнэлсэн бол дахин үнэлгээ хүчинтэй болсон хугацаа, хараат бус үнэлгээчин үнэлсэн эсэх, бусад биет бус хөрөнгийн бүрэлдэхүүн болон бусад тайлбар тэмдэглэлийг хийнэ).

--

11.ДУУСААГҮЙ БАРИЛГА

№	Дуусаагүй барилгын нэр	Эхэлсэн он	Дуусгалтын Хувь	Нийт төсөвт өртөг	Ашиглалтад орох эцсийн хугацаа
1	...				
2	...				
3	Нийт дүн				

12.БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

№	Биологийн хөрөнгийн төрөл	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		тоо	дансны үнэ	тоо	дансны үнэ
1	...				
2	...				
3	Нийт дүн				

Тэмдэглэл. (Биологийн хөрөнгийн хэмжилтийн суурь болон бусад тайлбар, тэмдэглэлийг хийнэ).

--

13.УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

№	Хөрөнгө оруулалтын төрөл	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		Хөрөнгө оруулалтын хувь	Хөрөнгө оруулалтын дүн	Хөрөнгө оруулалтын хувь	Хөрөнгө оруулалтын дүн
1	...				
2	...				
3	Нийт дүн				

Тэмдэглэл. (Урт хугацаат хөрөнгө оруулалттай холбоотой бий болсон олз, гарзын дүн, бүртгэсэн аргыг тодруулна. Охин компани, хамтын хяналттай аж ахуйн нэгж, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг НББОУС 27 Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн дагуу тодруулна).


14.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Тэмдэглэл. (Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд ашигласан хэмжилтийн суурь, бодит үнэ цэнийн загвар ашигладаг бол бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан арга, бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн олз, гарз, хэрэв түрээсэлдэг бол түрээсийн орлого, түрээсэлсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зардлууд. Хэрэв өртгийн загвар ашигладаг бол хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцох арга болон НББОУС 40 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөд заасны дагуу бусад тодруулгыг хийнэ).


15.БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	...		
2	...		
3	Нийт дүн		

Тэмдэглэл. (Бусад эргэлтийн бус хөрөнгийн төрөл тус бүрээр тайлбар, тэмдэглэлийг хийнэ. Урт хугацаат авлагыг тодруулна).


16.ӨР ТӨЛБӨР
--------------

16.1.Дансны өглөг

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<input type="checkbox"/> Төлөгдөх хугацаандаа байгаа		
2	<input type="checkbox"/> Хугацаа хэтэрсэн		
3	....		
4	Нийт дүн		

16.2.Татварын өр

№	Татварын өрийн төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ААНОАТ өр		
2	НӨАТ-ын өр		
3	ХХОАТ-ын өр		
4	ОАТ-ын өр		
5	Бусад татварын өр		
6	...		
7	Нийт дүн		

16.3.Богино хугацаат зээл

№	Ангилал	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		төгрөгөөр	валютаар	төгрөгөөр	валютаар
1	<input type="checkbox"/> Төлөгдөх хугацаандаа байгаа				
2	<input type="checkbox"/> Хугацаа хэтэрсэн				
3	....				
4	Нийт дүн				

16.4.Богино хугацаат нөөц (өр төлбөр)

№	Нөөцийн төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан (ашигласан нөөц) (-)	Ашиглаагүй буцаан бичсэн дүн	Эцсийн үлдэгдэл
1	Баталгаат засварын					
2	Нөхөн сэргээлтийн					
3	...					
4	Нийт дүн					

Тэмдэглэл. (Урт хугацаат нөөцийн дүнг тодруулна. Нөөцийн төрлөөр тайлбар, тэмдэглэл хийнэ).

--	--

16.5.Бусад богино хугацаат өр төлбөр

№	Төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	...		
2	Нийт дүн		

Тэмдэглэл. (Гадаад валютаар илэрхийлэгдсэн богино хугацаат өр төлбөрийн дүнг тусад нь тодруулна).

--

16.6.Урт хугацаат зээл болон бусад урт хугацаат өр төлбөр

№	Төрөл	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
		төгрөгөөр	валютаар	төгрөгөөр	валютаар
1	Урт хугацаат зээлийн дүн				
	Гадаадын байгууллагаас шууд авсан зээл				
	Гадаадын байгууллагаас дамжуулан авсан зээл				
	Дотоодын эх үүсвэрээс авсан зээл				
2	Бусад урт хугацаат өр төлбөрийн дүн (гадаад, дотоодын зах зээлд гаргасан бонд, өрийн бичиг)				
3	...				

Тэмдэглэл. (Урт хугацаат зээл болон бусад урт хугацаат өр төлбөрийн төрлөөр тайлбар, тэмдэглэл хийнэ).


17.ЭЗДИЙН ӨМЧ

17.1.Өмч

№	Ангилал	Эргэлтэд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа		Давуу эрхтэй хувьцаа		Өмчийн дүн (төгрөгөөр)
		Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	
1	Эхний үлдэгдэл					
2	Нэмэгдсэн					
3	Хасагдсан (-)					
4	Эцсийн үлдэгдэл					

17.2.Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

№	Үзүүлэлт	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл			
2	Нэмэгдсэн дүн			

	Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
	Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт			
3	Хасагдсан дүн (-)			
	Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
	Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз			
4	Эцсийн үлдэгдэл			

17.3.Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан (-)	Эцсийн үлдэгдэл
1	Гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс үүссэн зөрүү				
2	Бүртгэлийн валютыг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн зөрүү				
3	Бусад				
4	Нийт дүн				

17.4.Эздийн өмчийн бусад хэсэг

Тэмдэглэл. (Эздийн өмчийн бусад хэсгийн бүрэлдэхүүн тус бүрээр тодруулж тайлбар, тэмдэглэл хийнэ).


18.БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Борлуулалтын орлого:		
1.1	Бараа, бүтээгдэхүүн борлуулсны орлого:		
	...		
1.2	Ажил, үйлчилгээ борлуулсны орлого:		
	...		
1.3	Нийт борлуулалтын орлого		
2	Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт (-)		
3	Цэвэр борлуулалт		
4	Борлуулалтын өртөг:		
4.1	Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг		
	...		
4.2	Борлуулсан ажил, үйлчилгээний өртөг		
	...		
4.3	Нийт борлуулалтын өртөг		

19.БУСАД ОРЛОГО,ОЛЗ (ГАРЗ), АШИГ (АЛДАГДАЛ)

19.1.Бусад орлого

№	Орлогын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	...		
2	...		
3	Нийт дүн		

19.2.Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз

№	Төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэлийн ханшийн зөрүү		
2	Эргэлтийн авлага, өр төлбөртэй холбоотой үүссэн ханшийн зөрүү		
3	Эргэлтийн бус авлага, өр төлбөртэй холбоотой үүссэн ханшийн зөрүү		
4	Валютын арилжаанаас үүссэн олз/гарз		
5	Нийт дүн		

19.3.Бусад ашиг (алдагдал)

№	Ашиг (алдагдал)	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз		
2	ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз		
3	ХОЗҮХХ данснаас хассаны олз, гарз		
4	Хөрөнгийн дахин үнэлгээний олз, гарз		
5	Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз (гарзын буцаалт)		
6	...		
7	Нийт дүн		

20.ЗАРДАЛ

20.1.Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардлууд

№	Зардлын төрөл	Өмнөх оны дүн		Тайлант оны дүн	
		БорМар	ЕрУд	БорМар	ЕрУд
1	Ажиллагчдын цалингийн зардал				
2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал				
3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал				
4	Томилолтын зардал				
5	Бичиг хэргийн зардал				
6	Шуудан холбооны зардал				
7	Мэргэжлийн үйлчилгээний зардал				
8	Сургалтын зардал				
9	Сонин сэтгүүл захиалгын зардал				
10	Даатгалын зардал				
11	Ашиглалтын зардал				
12	Засварын зардал				
13	Элэгдэл, хорогдлын зардал				

14	Түрээсийн зардал				
15	Харуул хамгааллын зардал				
16	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал				
17	Тээврийн зардал				
18	Шатахууны зардал				
19	Хүлээн авалтын зардал				
20	Зар сурталчилгааны зардал				
21	...				
22	...				
23	Нийт дүн				

20.2.Бусад зардал

№	Зардлын төрөл	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Алданги, торгуулийн зардал		
2	Хандивын зардал		
3	Найдваргүй авлагын зардал		
4	...		
5	Нийт дүн		

20.3.Цалингийн зардал

Ангилал	Ажиллагчдын дундаж тоо	Цалингийн зардлын дүн	
		Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
Үйлдвэрлэл, үйлчилгээний			
Борлуулалт маркетингийн			
Ерөнхий ба удирдлагын			
Нийт дүн			

21.ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Тайлант үеийн орлогын татварын зардал		
2	Хойшлогдсон татварын зардал (орлого)		
3	Орлогын татварын зардал (орлого)-ын нийт дүн		

Тэмдэглэл. (Орлогын татварын зардал (орлого) – ын бүрэлдэхүүн тус бүрээр тайлбар, тэмдэглэл хийнэ).


**22.ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА**

22.1.Толгой компани, хамгийн дээд хяналт тавигч компани, хувь хүний талаарх мэдээлэл

Үзүүлэлт	Толгой компани	Хамгийн дээд хяналт тавигч толгой компани	Хамгийн дээд хяналт тавигч хувь хүн	Тайлбар
Нэр				
Бүртгэгдсэн (оршин суугаа) улс				
Эзэмшлийн хувь				

22.2.Тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд олгосон нөхөн олговрын тухай мэдээлэл:

Тэргүүлэх удирдлага гэдэгт ..... бүрэлдэхүүнийг хамруулав.

№	Нөхөн олговрын нэр	Өмнөх оны дүн	Тайлант оны дүн
1	Богино болон урт хугацааны тэтгэмж		
2	Ажил эрхлэлтийн дараах, ажлаас халагдсаны тэтгэмж		
3	Хувьцаанд суурилсан төлбөр		
4	Нийт дүн		

22.3.Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

№	Холбоотой талын нэр	Ажил гүйлгээний утга	Дүн	Тайлбар
1				
2				

**23.БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨР**

Тэмдэглэл. (Болзошгүй хөрөнгө ба өр төлбөрийн мөн чанар, хэрэв практик боломжтой бол тэдгээрийн санхүүгийн нөлөөний тооцооллыг тодруулна).


**24.ТАЙЛАГНАЛЫН ҮЕИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ**

Тэмдэглэл. (Тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал тус бүрийн хувьд мөн чанар, санхүүгийн нөлөөллийн тооцоолол зэргийг тодруулж бусад тайлбар, тэмдэглэл хийнэ).

25. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт (тегрөгөөр)							Эцсийн үлдэгдэл			
			Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр	Улсын төсвийн хөрөнгөөр	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Банкны зээл	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	Гадаадын зээл	Гадаадын буцалтгүй тусламж		Төсөл, хөтөлбөр, хандив	Бусад эх үүсвэр	Дүн
1	Биет хөрөнгө:												
1.1	Газрын сайжруулалт												
1.2	Барилга, байгууламж												
1.2.1	Үүнээс: Орон сууцны барилга												
1.2.2	Авто зам												
1.3	Машин тоног, төхөөрөмж												
1.4	Тээврийн хэрэгсэл												
1.5	Тавилга эд хогшил												
1.6	Компьютер, бусад хэрэгсэл												
1.7	Биологийн хөрөнгө												
1.8	Бусад биет хөрөнгө:												
1.9	Үүнээс: ХОЗУХХ <sup>1</sup>												
1.10	Биет хөрөнгийн дүн												
2	Биет бус хөрөнгө:												
2.1	Зохиогчийн эрх												
2.2	Компьютерын программ хангамж												
2.2.1	Үүнээс: Программ хангамж												
2.2.2	Мэдээллийн сан												
2.3	Патент												
2.4	Барааны тэмдэг												
2.5	Тусгай зөвшөөрөл												
2.6	Г азар эзэмших эрх												

<sup>1</sup> ХОЗУХХ – Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө



“Үнэт металл, үнэт чулууны өсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын зургаадугаар хавсралт



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖААНЫ НӨГДСЭН МЭДЭЭЛЭЛ

№	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	НИЙТ ТОО
<b>1</b>	<b>Худалдан авсан алтны нийт үнийн дүн</b>	
1.1	Нийт харилцагчдын тоо	
1.2	Бохир жин (грамм)	
1.3	АМНАТ-ийн суутгалын нийт үнийн дүн (төгрөг)	
<b>2</b>	<b>Худалдсан алтны нийт үнийн дүн</b>	
2.1	Нийт харилцагчдын тоо	
2.2	Бохир жин (грамм)	
2.3	АМНАТ-ийн суутгалын нийт үнийн дүн (төгрөг)	
<b>3</b>	<b>Худалдан авсан мөнгөний нийт үнийн дүн</b>	
3.1	Нийт харилцагчдын тоо	
3.2	Бохир жин (грамм)	
3.3	АМНАТ-ийн суутгалын нийт үнийн дүн (төгрөг)	
<b>4</b>	<b>Худалдсан мөнгөний нийт үнийн дүн</b>	
4.1	Нийт харилцагчдын тоо	
4.2	Бохир жин (грамм)	
4.3	АМНАТ-ийн суутгалын нийт үнийн дүн (төгрөг)	
<b>5</b>	<b>Худалдан авсан бусад үнэт металлын нийт үнийн дүн</b>	
5.1	Нийт харилцагчдын тоо	
5.2	Бохир жин (грамм)	
5.3	АМНАТ-ийн суутгалын нийт үнийн дүн (төгрөг)	
<b>6</b>	<b>Худалдсан бусад үнэт металлын нийт үнийн дүн</b>	
6.1	Нийт харилцагчдын тоо	
6.2	Бохир жин (грамм)	
6.3	АМНАТ-ийн суутгалын нийт үнийн дүн (төгрөг)	
<b>7</b>	<b>Худалдан авсан үнэт чулууны нийт үнийн дүн</b>	
7.1	Нийт харилцагчдын тоо	
7.2	Цэвэр жин (грамм)	
<b>СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ</b>		
8	Үнэт металл худалдсан этгээдийн төрөл (банк, дундын зуучлагчид, уран дархчууд гэх мэт.)	

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын долоодугаар хавсралт



ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ  
НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ

№	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	НИЙТ ДҮН
<b>1. ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ</b>		
1.1	<b>Импортоор оруулж ирсэн үнэт эдлэлийн нийт үнийн дүн:</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт үнийн дүн	
	мөнгөн эдлэлийн нийт үнийн дүн	
	бусад үнэт эдлэлийн нийт үнийн дүн	
	<b>Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн тоо	
	мөнгөн эдлэлийн тоо	
	бусад үнэт эдлэлийн тоо	
	<b>Нийт жин (грамм)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт жин	
мөнгөн эдлэлийн нийт жин		
бусад үнэт эдлэлийн нийт жин		
1.2	<b>Экспортын үнэт эдлэлийн нийт үнийн дүн:</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт үнийн дүн	
	мөнгөн эдлэлийн нийт үнийн дүн	
	бусад үнэт эдлэлийн нийт үнийн дүн	
	<b>Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн тоо	
	мөнгөн эдлэлийн тоо	
	бусад үнэт эдлэлийн тоо	
	<b>Нийт жин (грамм)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт жин	
мөнгөн эдлэлийн нийт жин		
бусад үнэт эдлэлийн нийт жин		
1.3	<b>Үнэт чулуу орсон эдлэлийн нийт үнийн дүн</b>	
	Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)	
	Нийт жин (грамм)	

**2.ХУДАЛДАН БОРЛУУЛСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ**

2.1	<b>Импортын үнэт эдлэлийн нийт үнийн дүн:</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт үнийн дүн	
	мөнгөн эдлэлийн нийт үнийн дүн	
	бусад үнэт эдлэлийн нийт үнийн дүн	
	<b>Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн тоо	
	мөнгөн эдлэлийн тоо	
	бусад үнэт эдлэлийн тоо	
	<b>Нийт жин (грамм)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт жин	
мөнгөн эдлэлийн нийт жин		
бусад үнэт эдлэлийн нийт жин		
2.2	<b>Экспортын үнэт эдлэлийн нийт үнийн дүн:</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт үнийн дүн	
	мөнгөн эдлэлийн нийт үнийн дүн	
	бусад үнэт эдлэлийн нийт үнийн дүн	
	<b>Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн тоо	
	мөнгөн эдлэлийн тоо	
	бусад үнэт эдлэлийн тоо	
	<b>Нийт жин (грамм)</b>	
	Үүнээс:	
	алтан эдлэлийн нийт жин	
мөнгөн эдлэлийн нийт жин		
бусад үнэт эдлэлийн нийт жин		
2.3	<b>Үнэт чулуу орсон эдлэлийн нийт үнийн дүн</b>	
	Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)	
	Нийт жин (грамм)	
3	<b>Худалдан авсан эртний эдлэлийн нийт үнийн дүн</b>	
3.1	Үүнээс:	
	алтаар хийсэн эртний эдлэлийн нийт үнийн дүн	

3.2	мөнгөөр хийсэн эртний эдлэлийн нийт үнийн дүн	
3.3	<b>Нийт тоо (ширхэг)</b>	
4	<b>Худалдан борлуулсан эртний эдлэлийн нийт үнийн дүн</b>	
4.1	Үүнээс: Алтаар хийсэн эртний эдлэлийн нийт үнийн дүн	
4.2	Мөнгөөр хийсэн эртний эдлэлийн нийт үнийн дүн	
4.3	<b>Нийт тоо (ширхэг)</b>	
<b>5. СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ</b>		
5.1	Эзэмшиж буй лангууны нийт тоо	
5.2	Бүтээгдэхүүний брэндийн нэр	
5.3	Франчайз эрхтэй эсэх	
5.4	Хамгийн их борлуулалттай бүтээгдэхүүн	

“Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээр хийсэн эдлэлийн арилжаа өрхлөгчийн Үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын наймдугаар хавсралт



АЛТНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

Арилжаа эрхлэгчийн нэр:										
№	Огноо	Худалдсан/ худалдан авсан (сонгох)	Сорьц	Нэгжийн үнэ	Бохир жин (грамм)	АМНАТ-ын суутгал (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Алт олборлосон аймаг, сум	Алт худалдсан банкны нэр	Мэдээллийн эзэн зөвшөөрсөн эсэх
1										
2										
...										
<b>Нийт</b>										

“Үнэт металл, Үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн  
 эдлэлийн арилжаа эрхлэгчийн Үйл ажиллагаанд  
 зайны бодон газар дээрх хяналт шалгалт хийх  
 журам”-ын есдүгээр хавсралт



МОНГОНИЙ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

Арилжаа эрхлэгчийн нэр:

№	Огноо	Худалдсан/ худалдан авсан (сонгох)	Сорьц	Нэгжийн үнэ	Бохир жин (грамм)	АМНАТ-ын суутгал (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Мөнгө олборлосон аймаг, сум	Мөнгө худалдсан банкны нэр	Мэдээллийн эзэн зөвшөөрсөн эсэх
1										
2										
...										
<b>Нийт</b>										



“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын аравдугаар хавсралт

БУСАД МЕТАЛЛЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

Арилжаа эрхлэгчийн нэр:

№	Огноо	Худалдсан/ худалдан авсан (сонгох)	Сорьц	Нэгжийн үнэ	Бохир жин (грамм)	АМНАТ-ын суутгал (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Тухайн үнэт металлыг олборлосон аймаг, сум	Үнэт металл худалдсан банкны нэр	Мэдээллийн эзэн зөвшөөрсөн эсэх
1										
2										
...										
<b>Нийт</b>										

“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн  
 эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд  
 зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх  
 журам”-ын арван нэгдүгээр хавсралт



ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

Арилжаа эрхлэгчийн нэр:

№	Огноо	Үнэт чулууны нэр, төрлийг сонгоно уу. (Доржпалам, Бадмаараг, Маргад эрдэнэ, Индранил, Сувд)	Худалдсан/ худалдан авсан (сонгох)	Цэвэр жин (грамм)	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	ОУЗЗҮнэ ам.доллар	Тухайн үнэт чулууг олборлосон аймаг, сум	Мэдээллийн эзэн зөвшөөрсөн эсэх
1									
2									
...									
<b>Нийт</b>									

“Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын арван хоёрдугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/CC/00

Арилжаа эрхлэгчийн нэр:

№	Үнэт металлын нэр	Худалдан авсан үнэт эдлэлийн мэдээлэл				Худалдан борлуулсан үнэт эдлэлийн мэдээлэл				Үнэт чулууны нэр <sup>2</sup>	Мэдэглэлийн эзэн эвсгөөрөөс эсэх	
		Импортын үнэт эдлэлийн мэдээлэл		Экспортын үнэт эдлэлийн мэдээлэл		Импортын үнэт эдлэлийн мэдээлэл		Экспортын үнэт эдлэлийн мэдээлэл				
		Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)	Нийт жин (грамм)	Нийт үнийн дүн (төгрөг)	Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)	Нийт жин (грамм)	Нийт үнийн дүн (төгрөг)	Үнэт эдлэлийн нийт тоо (ширхэг)	Нийт жин (грамм)			Нийт үнийн дүн (төгрөг)
	Нийт											
1	Алт											
2	Мөнгө											
3	Платина											
4	Палладий											
5	Иридий											
6	Родий											
7	Рутений											
8	Осми											

<sup>2</sup> Үнэт металаар хийсэн эдлэлд Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасан үнэт чулуу (доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувд) орсон тохиолдолд нэрсийг бичнэ үү.



“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл-тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын арван гуравдугаар хавсралт

ЭРТНИЙ ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

Арилжаа эрхлэгчийн нэр:								
№	Эртний эдлэлийн нэр	Үнэт металлын нэр <sup>3</sup>	Үнэт чулууны нэр <sup>4</sup>	Худалдсан/ худалдан авсан	Тоо (ширхэг)	Нийт үнэ (төгрөг)	Эртний эдлэлийн гарал үүсэл <sup>5</sup>	Мэдээллийн эзэн зөвшөөрсөн эсэх
1								
2								
3								
...								
<b>Нийт</b>								

<sup>3</sup> Эртний эдлэлд Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасан үнэт металл (алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг) орсон тохиолдолд нэрсийг бичнэ үү.

<sup>4</sup> Эртний эдлэлд Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасан үнэт чулуу (доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувдыг) орсон тохиолдолд нэрсийг бичнэ үү.

<sup>5</sup> Эртний эдлэлийн гарал үүслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү.